

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Халзан сумын Засаг даргын Тамгын газар 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2022/47/НА-СБА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баруун-Урт хот 2022 он	Сүхбаатар аймаг дахь төрийн аудитын газрын тэргүүлэх аудитор: М.Нарантуяа  Утас: 70518369 Цахим хаяг: <a href="mailto:narantuyam@audit.gov.mn">narantuyam@audit.gov.mn</a> Аудитын менежер: Г.Даваа Утас: 70512123 Цахим хаяг: <a href="mailto:davaag@audit.gov.mn">davaag@audit.gov.mn</a> Аудитор: О.Барчидгүнсэн Утас: 70512127 Цахим хаяг: <a href="mailto:barchidgunseno@audit.gov.mn">barchidgunseno@audit.gov.mn</a>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт .....	16
4.1 Төлбөрийн акт.....	16
4.2 Албан шаардлага .....	16
4.3 Зөвлөмж .....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	17

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ЗГНХ	Засаг даргын нөөц хөрөнгө



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг  
Утас: 70518396, Факс: 70518396  
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

СҮХБААТАР АЙМГИЙН ХАЛЗАН СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА М.БАТБЭХ ТАНАА

2022.08.25 № 61

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Халзан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Халзан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>32,398,858.18</u></b>	<b><u>44,456,516.18</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	00.00	6,851,800.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	00.00	6,851,800.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	6,851,800.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	27,070,858.18	27,224,716.18
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	19,293,010.18	22,224,716.18
35410	Бичиг хэргийн материал	1,252,560.00	1,273,390.00
35420	Аж ахуйн материал	16,187,550.00	16,187,550.00
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	1,749,876.00
35470	Бусад хангамжийн материал	1,852,900.18	3,013,900.18
35600	Мал амьтад	7,777,848.00	5,000,000.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	5,328,000.00	10,380,000.00
36600	Бусад нөөц	5,328,000.00	10,380,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,224,365,263.00</u></b>	<b><u>1,241,084,377.97</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,224,365,263.00	1,241,084,377.97
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,206,835,263.00	1,223,554,377.97
39201	Барилга, байгууламж, орон сууц	998,999,585.48	1,042,999,585.48
39202	Хуримтлагдсан элэгдэл	-233,979,997.98	-272,708,368.83
39203	Авто-тээврийн хэрэгсэл	147,404,800.00	165,204,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-146,157,400.00	-128,573,200.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	126,487,490.00	129,865,490.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-75,472,781.75	-88,041,436.01
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	113,273,364.00	116,833,364.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-50,341,569.06	-60,261,828.22
39214	Бусад үндсэн хөрөнгө	140,855,581.13	145,731,841.13
39215	Хуримтлагдсан элэгдэл	-58,233,808.82	-71,495,869.58
39216	Дуусаагүй барилга, байгууламж	244,000,000.00	244,000,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	17,530,000.00	17,530,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	17,530,000.00	17,530,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,256,764,121.18</u></b>	<b><u>1,285,540,894.15</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>6,020,263.88</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	6,020,263.88	00.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	6,020,263.88	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	6,020,263.88	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,250,743,857.30</u></b>	<b><u>1,285,540,894.15</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,250,743,857.30	1,285,540,894.15
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	939,258,283.51	939,258,283.51
51101	Өмч: - төрийн	939,258,283.51	939,258,283.51
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	220,247,699.95	255,044,736.80
51210	Өмнөх үеийн үр дүн	220,247,699.95	220,247,699.95
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	34,797,036.85
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	91,237,873.84	91,237,873.84
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,256,764,121.18</u></b>	<b><u>1,285,540,894.15</u></b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>493,195,256.00</b>	<b>609,518,655.50</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>98,747,416.00</b>	<b>102,064,456.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	98,747,416.00	102,064,456.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	98,747,416.00	102,064,456.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,616,000.00	5,477,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	96,131,416.00	96,587,456.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>394,447,840.00</b>	<b>507,454,199.50</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	19,600,140.00	50,435,899.50
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,400,000.00	6,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,200,000.00	25,275,360.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,860,140.00	18,370,539.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	140,000.00	790,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	374,847,700.00	457,018,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	374,847,700.00	457,018,300.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>489,624,859.88</b>	<b>574,721,618.65</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>489,624,859.88</b>	<b>574,721,618.65</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	465,417,632.94	500,120,192.35
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	216,778,795.14	234,696,143.44
210101	Үндсэн цалин	216,778,795.14	210,726,126.68
210102	Нэмэгдэл	00.00	21,341,609.66
210104	Урамшуулал	00.00	2,628,407.10
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	36,811,502.74	30,666,913.57
210201	Тэтгэврийн даатгал	27,892,492.82	21,625,029.73
210202	Тэтгэмжийн даатгал	2,405,994.48	2,399,074.65
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,796,699.58	1,897,060.47
210204	Ажилгүйдлийн даатгал	449,099.90	431,440.72
210205	Эрүүл мэндийн даатгал	4,267,215.96	4,314,308.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	33,312,592.62	49,308,366.00
210301	Гэрэл, цахилгаан	3,024,096.62	3,604,978.00
210302	Түлш, халаалт	29,538,496.00	30,410,688.00
210303	Цэвэр, бохир ус	750,000.00	15,292,700.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	24,939,595.00	16,035,445.00
210401	Бичиг хэрэг	2,744,845.00	3,205,770.00
210402	Тээвэр, шатахуун	9,089,902.00	6,682,177.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,226,600.00	2,469,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,100,400.00	899,750.00
210408	Бараа материал акталсны зардал	7,777,848.00	2,777,848.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	320,000.00	323,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	320,000.00	323,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,900,630.00	467,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	446,700.00	152,700.00
210604	Урсгал засвар	2,453,930.00	315,000.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	1,874,000.00	3,064,662.50
210702	Дотоод албан томиллолт	1,874,000.00	3,064,662.50
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	11,163,600.00	35,165,351.81

**Халзан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,277,800.00	34,699,526.81
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	235,200.00	172,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	101,400.00	221,725.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	9,200.00	71,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>137,316,917.44</b>	<b>130,392,610.03</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,663,006.00	55,215,935.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	801,000.00	281,530.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	99,852,911.44	74,895,145.03
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>24,207,226.94</b>	<b>74,601,426.30</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>9,950,550.00</b>	<b>34,487,060.00</b>
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	5,952,580.00	5,952,660.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	26,034,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,997,970.00	2,500,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>14,256,676.94</b>	<b>40,114,366.30</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,256,676.94	40,114,366.30
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>3,570,396.12</u></b>	<b><u>34,797,036.85</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>3,570,396.12</u></b>	<b><u>34,797,036.85</u></b>

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	939,258,283.51	91,237,873.84	295,756,290.48	00.00	1,326,252,447.83
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>939,258,283.51</b>	<b>91,237,873.84</b>	<b>295,756,290.48</b>	<b>00.00</b>	<b>1,326,252,447.83</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-86,856,835.21	00.00	-86,856,835.21
C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>939,258,283.51</b>	<b>91,237,873.84</b>	<b>220,247,699.95</b>	<b>00.00</b>	<b>1,250,743,857.30</b>
D01	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>939,258,283.51</b>	<b>91,237,873.84</b>	<b>220,247,699.95</b>	<b>00.00</b>	<b>1,250,743,857.30</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>939,258,283.51</b>	<b>91,237,873.84</b>	<b>220,247,699.95</b>	<b>00.00</b>	<b>1,250,743,857.30</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	34,797,036.85	00.00	34,797,036.85
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>939,258,283.51</b>	<b>91,237,873.84</b>	<b>255,044,736.80</b>	<b>00.00</b>	<b>1,285,540,894.15</b>

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>397,063,840.00</u></b>	<b><u>506,329,399.50</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,616,000.00</b>	<b>5,477,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	2,616,000.00	5,477,000.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	2,616,000.00	5,477,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,616,000.00	5,477,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>394,447,840.00</b>	<b>500,852,399.50</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	19,600,140.00	43,834,099.50
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,400,000.00	6,000,000.00

Халзан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,200,000.00	25,275,360.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,860,140.00	11,768,739.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	140,000.00	790,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	00.00	457,018,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	457,018,300.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	374,847,700.00	00.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	374,847,700.00	00.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>396,563,840.00</b>	<b>499,391,399.50</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>396,563,840.00</b>	<b>499,391,399.50</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>372,356,613.06</b>	<b>424,789,973.20</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	235,334,908.00	240,966,407.32
210101	Үндсэн цалин	235,334,908.00	216,996,390.56
210102	Нэмэгдэл	00.00	21,341,609.66
210104	Урамшуулал	00.00	2,628,407.10
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	30,418,329.44	30,666,913.57
210201	Тэтгэврийн даатгал	21,275,235.52	21,625,029.73
210202	Тэтгэмжийн даатгал	2,405,994.48	2,399,074.65
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,796,699.58	1,897,060.47
210204	Ажилгүйдлийн даатгал	449,099.90	431,440.72
210205	Эрүүл мэндийн даатгал	4,491,299.96	4,314,308.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	35,816,302.62	49,308,366.00
210301	Гэрэл, цахилгаан	3,073,876.62	3,604,978.00
210302	Түлш, халаалт	31,992,426.00	30,410,688.00
210303	Цэвэр, бохир ус	750,000.00	15,292,700.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	17,649,517.00	13,024,627.00
210401	Бичиг хэрэг	3,070,800.00	2,910,000.00
210402	Тээвэр, шатахуун	9,089,902.00	6,682,177.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,358,415.00	2,535,900.00
210404	Ном, хэвлэл	00.00	78,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,130,400.00	818,550.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	320,000.00	500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	320,000.00	500,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	800,000.00	560,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	800,000.00	422,000.00
210604	Урсгал засвар	00.00	138,700.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,874,000.00	3,064,662.50
210702	Дотоод албан томилолт	1,874,000.00	3,064,662.50
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	14,420,700.00	32,824,467.81
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,534,900.00	32,358,642.81
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	235,200.00	172,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	101,400.00	221,725.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	9,200.00	71,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	35,722,856.00	53,873,829.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,921,856.00	53,592,299.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	801,000.00	281,530.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>24,207,226.94</b>	<b>74,601,426.30</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	9,950,550.00	34,487,060.00

Халзан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	5,952,580.00	5,952,660.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	26,034,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,997,970.00	2,500,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>14,256,676.94</b>	<b>40,114,366.30</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,256,676.94	40,114,366.30
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>500,000.00</u></b>	<b><u>6,938,000.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>500,000.00</b>	<b>6,938,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>500,000.00</b>	<b>6,938,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>500,000.00</b>	<b>6,938,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	500,000.00	6,938,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-500,000.00</u></b>	<b><u>-6,938,000.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	462,018,300.00	434,726,143.70
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	462,018,300.00	434,726,143.70
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	428,530,500.00	401,239,083.70
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	254,771,400.00	240,966,407.32
210101	Үндсэн цалин	176,998,500.00	216,996,390.56
210102	Нэмэгдэл	70,597,200.00	21,341,609.66
210104	Урамшуулал	7,175,700.00	2,628,407.10
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	34,041,700.00	30,666,913.57
210201	Тэтгэврийн даатгал	23,851,100.00	21,625,029.73
210202	Тэтгэмжийн даатгал	2,547,700.00	2,399,074.65
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,038,200.00	1,897,060.47
210204	Ажилгүйдлийн даатгал	509,600.00	431,440.72
210205	Эрүүл мэндийн даатгал	5,095,100.00	4,314,308.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	34,360,700.00	34,345,666.00
210301	Гэрэл, цахилгаан	3,200,000.00	3,604,978.00
210302	Түлш, халаалт	30,410,700.00	30,410,688.00
210303	Цэвэр, бохир ус	750,000.00	330,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	13,555,700.00	12,503,550.00
210401	Бичиг хэрэг	2,800,000.00	2,800,000.00
210402	Тээвэр, шатахуун	6,305,700.00	6,301,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,500,000.00	2,505,900.00
210404	Ном, хэвлэл	150,000.00	78,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	800,000.00	818,550.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	500,000.00	500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	500,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	5,300,000.00	5,298,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	800,000.00	623,700.00
210602	Тавилга	3,000,000.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,675,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,590,000.00	2,822,000.00

Халзан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт	3,590,000.00	2,822,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>31,111,000.00</b>	<b>23,749,467.81</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,950,000.00	23,283,642.81
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	172,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	240,000.00	221,725.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,000.00	71,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>51300000.00</b>	<b>50386379.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	51,000,000.00	50,104,849.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300,000.00	281,530.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>33487800.00</b>	<b>33487060.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>33,487,800.00</b>	<b>33,487,060.00</b>
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	5,953,400.00	5,952,660.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,034,400.00	26,034,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,500,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>462,018,300.00</b>	<b>434,726,143.70</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>457,018,300.00</b>	<b>433,362,843.70</b>
132001	Орон нутгийн төсвөөс	457,018,300.00	433,362,843.70
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>5,000,000.00</b>	<b>1,363,300.00</b>
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	1,363,300.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>21.00</b>	<b>20.00</b>
620001	Удирдах ажилтан	07.00	07.00
620002	Гүйцэтгэх ажилтан	11.00	10.00
620003	Үйлчлэх ажилтан	03.00	03.00

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>31,488,889.50</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>31,488,889.50</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>30,488,889.50</b>
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>14,962,700.00</b>
210303	Цэвэр, бохир ус	14,962,700.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>521,077.00</b>
210401	Бичиг хэрэг	110,000.00
210402	Тээвэр, шатахуун	381,077.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>242,662.50</b>
210702	Дотоод албан томилолт	242,662.50
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>11,275,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,275,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3487450.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,487,450.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1000000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,000,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>31488889.50</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>31,488,889.50</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	6,000,000.00

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,930,150.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,768,739.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	790,000.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Халзан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-наас 2022 оны 2 дугаар сарын 25-ны хооронд Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Барчидгүнсэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Халзан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Халзан сумын Засаг даргын Тамгын газар нь “Үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн зөв бодлого, зөв үйлдэл, зөв манлайллыг түүчээлэгч төрийн байгууллага болно гэсэн зорилт дэвшүүлэн үйл ажиллагаандаа 434.7 сая төгрөгийг зарцуулан ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Халзан сумын Засаг даргын тамгын газар төвд тайлант хугацаанд Санхүүгийн хяналт аудитын албаны төлөвлөгөөт шалгалтыг засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явц, санхүүгийн тайлангийн үр дүн нөлөөтэй байдлыг үнэлж дүгнэж, санхүү төсвийг зохистой удирдах, өр үүсэхгүй ажиллах зөвлөмж өгчээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Халзан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн нь хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд нийт ажил гүйлгээний ихэнх хувийг зардлын гүйлгээ эзэлдэг бөгөөд төсвийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байдлыг татвар төлөгч, иргэд илүү анхаардаг учир материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 481.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 7.2 сая, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 5.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Халзан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 28.7 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая.төг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1

<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	32.4	44.4	12.0
<b>Авлага</b>	0.00	6.8	6.8
<b>Бусад авлага</b>	0.00	6.8	6.8
<b>Бараа материал</b>	27.0	27.2	0.15
<b>Үндсэн хөрөнгө</b>	1,224.3	1,241.1	16.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,256.7</b>	<b>1,285.5</b>	<b>28.7</b>
<b>Өр төлбөр</b>	6.0	0.00	6.0
<b>Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/</b>	1,250.7	1,285.5	34.7
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,256.7</b>	<b>1,285.5</b>	<b>28.7</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 27.2 сая төгрөг болж 0.15 сая төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,862.1 сая төгрөг болж 73.6 сая төгрөгөөр өссөн нь Аймгийн засаг даргын тамгын газраас машин 35.8 сая, барилгын дээврийн сайжруулалт 44.0 сая, бусад хөрөнгө 4.8 нийт 84.6 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй шилжиж ирсэн бөгөөд төсвийн хөрөнгөөр худалдан авсан тоног төхөөрөмж, тавилга 6.9 сая нийт 91.6 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, онгон суманд машин шилжүүлсэн 18.0 сая, элэгдлийн зардал 74.8 сая төгрөгийн болж хөрөнгө буурсан байна.

Авлагын дансны үлдэгдэл 6.8 сая төгрөг болж өссөн нь төвлөрүүлсэн санхүүжилтийн авлага байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1.285.5 сая төгрөг болж 28.7 сая төгрөгөөр өссөн байна.

Халзан сумын Засаг даргын Тамгын газар санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 116.3 сая төгрөгөөр буюу 23.5 хувиар өссөн нь орон нутгийн санхүүжилт 82.1 сая, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 30.8 сая, үндсэн үйл ажиллагааны санхүүжилт 2.8 сая нийт 115.7 сая төгрөгөөр нэмэгдсэн, бөгөөд үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 0.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нөлөөлжээ.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь урсгал үйл ажиллагааны санхүүжилт, дээд шатын төсөв захирагчаас үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 85.1 сая төгрөг буюу 17.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь засаг даргын нөөц сан, мөрийн хөтөлбөрийн зардлууд нэмэгдсэнтэй холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 397.4 сая төгрөгөөр, нийт зарлагыг 397.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 457.0 сая, үндсэн үйл ажиллагааны санхүүжих 5.0 сая, нийт 462.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс санхүүжих 433.3 сая, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1.3 сая төгрөгийг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 434.7 сая төгрөгийг зарцуулж, 27.8 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсөв захирагчаас 11.7 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 0.8 сая, ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 25.2 сая, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж 6.0 сая нийт 43.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цэвэр бохир усны зардал 30.4 сая, хангамжийн бараа материал 14.9 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 11.4 сая, бараа үйлчилгээний бусад зардал 3.5 сая, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал 1.0 сая, нийт 31.5 сая төгрөгийн гүйцэтгэл гарч 12.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

Тайлант онд сумын аймгийн засаг даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгуулж, 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээнд зориулан төлөвлөсөн төсвийн гүйцэтгэл 79.9 хувийн биелэлттэй байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал ажиглагдаагүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах асуудал гараагүй.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд оруулбал зохих 146 мэдээллээс хугацаандаа оруулсан 141 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл 5, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагыг мэдээлэл шилэн дансны цахим хуудсанд байршуулжээ.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолоор төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг бүх шатны байгууллагын төсөв захирагч нарт даалгасан байна. Тухайлбал:

- Тогтоолын 1.1-д “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”
- Тогтоолын 1.8-д “байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах; гэж заасан байна”

Сангийн яамнаас 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн “Тодруулга хүргүүлэх тухай” Н-3/845 дугаар албан бичгийг Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна. Тус албан бичигт “Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д заасан “үндсэн үйл ажиллагаатай холбоотой зайлшгүй шаардлагатай зардал, төсөл, арга хэмжээ” гэдэгт төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор ажилтан, албан хаагчдад төлж байгаа цалин хөлс, олговор, ажил олгогчоос төлөх нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, цахилгаан, халаалт, цэвэр, бохир ус, түрээсийн зардал болон байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой шаардлагатай бусад зардал хамаарна.” гэж тодруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт, зөвлөмж, зөрчлийг арилгах албан шаардлагыг бүрэн биелүүлжээ.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Халзан сумын Засаг даргын тамгын газрын тайлант оны үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл, ажил гүйлгээ болон санхүүгийн тайланг тасалбар болгож гаргасан өдрөөс хойших үйл явдлыг шинжилж үзэхэд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 18.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 0.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 17.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 1 асуудалд зөвлөмж өгсөн.

##### 4.1 Төлбөрийн акт

4.1.1 Анх шатны баримтаар нотлогдохгүй 0.3 сая төгрөгийг засаг даргын нөөц сангийн зардлаас бэлнээр гаргасан зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, 16 дугаар зүйлийн 16.5.5 /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/, 41 дүгээр зүйлийн 41.2.3 /төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах/ Нягтлан бодох бүртгэлийн тухай 13 дугаар зүйлийн 13.7 /Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно/, 20 дугаар зүйлийн 20.1.4./хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй / дахь заалттай нийцэхгүй байна.

4.1.2 Засгийн газраас олгож байгаа усны үнэ 0.6 сая төгрөгийг засаг даргын нөөц сангаас давхардуулж олгосон зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, 16 дугаар зүйлийн 16.5.5 /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/, 41 дүгээр зүйлийн 41.2.3 /төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах/, Засгийн газрын 2020 оны 211 тоот тогтоолтой нийцэхгүй байна.

##### 4.2 АЛБАН ШААРДЛАГА

4.2.1 Засаг даргын нөөц сан, мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас гарсан тээвэр шатахууны зарцуулалтад замын хуудсыг бүрэн, тодорхой, иж бүрэн хөтлөөгүй, дотоод хяналт сул, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулаагүй зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1/ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, 6.4.2 /төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх/, 16 дугаар зүйлийн 16.5.5 /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/ заалт, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал болон болон ажил гүйлгээний анги, үйл явдал, холбогдох тодруулгын иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2.2 Бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас худалдан авсан бараа, ажил үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.21-т заасан хэрэглэгчийн системтэй этгээдээс худалдан авалт хийсэн боловч төлбөрийн баримтыг хавсраагүй, өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж хэрэгжээгүй зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1/ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, 6.4.2 /төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх/ заалт, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалтай болон ажил гүйлгээний анги, үйл явдал, холбогдох тодруулгын иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2.3 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор Ковид-19 цар тахлын нөхцөлд төсвийг үр ашигтай зарцуулж, хэмнэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг баталсан. Уг тогтоолыг баримтлалгүй мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас гэрэлтүүлэг, гэрлэн хаяг хийлгэсэн, зарим малчдын малыг ээмэгжүүлсэн, зураг төсөв хийлгэх зардал, байгууллага сурталчилж нэвтрүүлэг хийлгэсний хөлс, нийт 17.5 сая төгрөгийг зарцуулсан зөрчил илэрсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1/ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, 6.4.2 /төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх/, 16 дугаар зүйлийн 16.5.5 /батлагдсан төсвийг зориулалтын дагуу

зарцуулах/ заалт, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол болон иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2.4 Багын даргаар ажиллаж байсан Г.Цэнгэлмаад сахилгын шийтгэл буруу ногдуулсан болохыг шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоосон бөгөөд цалингаас суутгасан хөлсийг төсвөөс олгож, буруу шийдвэр гаргасан холбогдох этгээдээр буцаан төлүүлээгүй зөрчил илэрлээ. Энэ нь Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5 /Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй./, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 /Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ./, 103.2 / Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна./ дахь заалтыг зөрчсөн

#### 4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 4.3.1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

###### 4.3.1.1 Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 62 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчил нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан "Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана" заалттай нийцэхгүй байна.

###### 4.3.1.2. Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Халзан сумын Засаг даргын тамгын газар	7	18.4	-	-	2	0.9	4	17.5	1	-

/сая төгрөгөөр/

